



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/03

Ховд

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Захиалагчаас байгуулсан худалдан авах ажиллагааг зохион байгуулах чиг үүрэг бүхий “Үнэлгээний хорооны үйл ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.


2. Тус журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газар /Ш.Нохойжав/, Үнэлгээний хорооны дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны
өдрийн А/03 дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүний зохион байгуулалт, үйл ажиллагаа, тендер шалгаруулалтын явцыг нээлттэй, ил тод, шударга зохион байгуулах харилцааг зохицуулахад оршино.

1.2. Захиалагч нь хуульд зааснаар Үнэлгээний хороо байгуулан зохион байгуулж буй тендер шалгаруулалттай холбоотой урилга нийтлэх, үнэлгээний хорооны хуралдааныг зохион байгуулах, үнэлгээний дүгнэлт гаргах, тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлэх харилцаанд энэ журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Үнэлгээний хороо байгуулах, өөрчлөлт оруулах, татан буулгах

2.1. Захиалагч хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасан тохиолдолд үнэлгээний хороо заавал байгуулна.

2.2. Захиалагчийн шийдвэрээр үнэлгээний хороог шинээр байгуулж, өөрчлөлт оруулан, татан буулгана.

2.3. Захиалагч үнэлгээний хороо татан буулгасан тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн дагуу түүний эрх, үүргийг захиалагч залгамжилна.

2.4. Үнэлгээний хорооны гишүүд хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

2.5. Үнэлгээний хорооны гишүүд нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 5-аас доошгүй сондгой тооны гишүүдтэй байна.

2.6. Үнэлгээний хороо үйл ажиллагаа явуулж байх хугацаанд тухайн үнэлгээний хорооны гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар үргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон эсхүл үнэлгээний хорооны гишүүнээр ажиллах эрхгүй болсон

бол захиалагч нэн даруй шийдвэр гаргаж түүнийг үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлөх ба шаардлагатай шинэ гишүүнийг нөхөн томилно.

2.7. Үнэлгээний хорооны бусад зохион байгуулалтын асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэнэ.

Гурав. Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, нээлттэй, ил тод байдал

3.1. Үнэлгээний хороо, түүний гишүүд нь хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хуулийн 6 дугаар зүйлд заасан худалдан авах ажиллагааны зарчмаас гадна хараат бус байх, ил тод, шударга ажиллах зарчмыг баримтална.

3.2. Үнэлгээний хороо, түүний гишүүд нь тендер шалгаруулалтыг зохион байгуулах, тендер үнэлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан журам, аргачлалыг мөрдөх бөгөөд хуульд зааснаас бусад арга хэлбэрээр тендер оролцогч болон түүний эрх, ашгийг төлөөлөн илэрхийлж буй аливаа этгээдтэй харилцаа тогтоохгүй байна.

3.3. Үнэлгээний хорооны дарга нь хуралдааныг товлох, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах, үнэлгээний хорооны үйл ажиллагааг хуульд нийцүүлэн удирдан зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, тендер шалгаруулалтыг нээлттэй, ил тод, шударга явуулах үүргийг хүлээнэ.

3.4. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд багтаан хурдан шуурхай зохион байгуулах бөгөөд энэ зорилгоор тендерийг хянан үзэх, үнэлэх хуралдааныг тендер нээсэн өдөрт багтаан зохион байгуулж, дүгнэлтээ гаргана.

3.5. Үнэлгээний хорооны хуралдаан, тендер үнэлэх явцыг нээлттэй, ил тод байлгах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын танхимд цахим дэлгэцээр дуу, дүрстэйгээр шууд дамжуулж, тендер оролцогч болон бусад хөндлөнгийн ажиглагчдыг хяналт тавих боломжоор хангана.

3.6. Үнэлгээний хорооны дарга, гишүүд хараат бус байх, хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй байх үүднээс тендерийг үнэлэх явцад хуралдааны танхимд утсаар ярих болон танхимаас гарахыг хориглоно.

3.7. Үнэлгээний хорооны хуралдааныг цахим дэлгэцээр шууд дамжуулах техник, тоног төхөөрөмж болон бусад асуудлыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

Дөрөв. Үнэлгээний хорооны хуралдаан, үнэлгээний дүгнэлт

4.1. Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанаас хамтын шийдвэр гаргана.

бол захиалагч нэн даруй шийдвэр гаргаж түүнийг үнэлгээний хорооны гишүүнээс чөлөөлөх ба шаардлагатай шинэ гишүүнийг нөхөн томилно.

2.7. Үнэлгээний хорооны бусад зохион байгуулалтын асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлэнэ.

Гурав. Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, нээлттэй, ил тод байдал

3.1. Үнэлгээний хороо, түүний гишүүд нь хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэхдээ хуулийн 6 дугаар зүйлд заасан худалдан авах ажиллагааны зарчмаас гадна хараат бус байх, ил тод, шударга ажиллах зарчмыг баримтална.

3.2. Үнэлгээний хороо, түүний гишүүд нь тендер шалгаруулалтыг зохион байгуулах, тендер үнэлэхдээ холбогдох хууль тогтоомжид заасан журам, аргачлалыг мөрдөх бөгөөд хуульд зааснаас бусад арга хэлбэрээр тендер оролцогч болон түүний эрх, ашгийг төлөөлөн илэрхийлж буй аливаа этгээдтэй харилцаа тогтоохгүй байна.

3.3. Үнэлгээний хорооны дарга нь хуралдааныг товлох, хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах, үнэлгээний хорооны үйл ажиллагааг хуульд нийцүүлэн удирдан зохион байгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, тендер шалгаруулалтыг нээлттэй, ил тод, шударга явуулах үүргийг хүлээнэ.

3.4. Үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг хуулийн хугацаанд багтаан хурдан шуурхай зохион байгуулах бөгөөд энэ зорилгоор тендерийг хянан үзэх, үнэлэх хуралдааныг тендер нээсэн өдөрт багтаан зохион байгуулж, дүгнэлтээ гаргана.

3.5. Үнэлгээний хорооны хуралдаан, тендер үнэлэх явцыг нээлттэй, ил тод байлгах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын танхимд цахим дэлгэцээр дуу, дүрстэйгээр шууд дамжуулж, тендер оролцогч болон бусад хөндлөнгийн ажиглагчдыг хяналт тавих боломжоор хангана.

3.6. Үнэлгээний хорооны дарга, гишүүд хараат бус байх, хөндлөнгийн нөлөөлөлд автахгүй байх үүднээс тендерийг үнэлэх явцад хуралдааны танхимд утсаар ярих болон танхимаас гарахыг хориглоно.

3.7. Үнэлгээний хорооны хуралдааныг цахим дэлгэцээр шууд дамжуулах техник, тоног төхөөрөмж болон бусад асуудлыг аймгийн Засаг даргын Тамгын газар хариуцна.

Дөрөв. Үнэлгээний хорооны хуралдаан, үнэлгээний дүгнэлт

4.1. Үнэлгээний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хуралдаанаас хамтын шийдвэр гаргана.